

Хилийн доторхи дархан хил

**(Нэрт эрдэмтэн, чацаргана судлаач Б. Лааганы тухай
“Дарь үнэрлэж, чацаргана нүүлгэсэн жилүүд” номоос)**

Аав, хvv хоёр хонио голдуу цугтаа бэлчээнэ. Цастай талаар зурайсан замаар хонь бэлчээр рvнгээ цувна. Овлийн улиралд хонио боон маягаар бэлчээрт нь тууж хvргэдэг, орой болоход мон л дээрх замаараа тууж харихаа хоньчин хvv ч, хонин сvрэг нь ч андахгvй. Замаас нэг л хонь гарсан байвал хvv буруудна. Аав ч зэмлэнэ. Хэрэв зээ олон хонь замаас гаргаж, шинэ бэлчээр тахачсан байвал бvвр хэрэг мандана. Хонь мал яваагvй онгон бэлчээрээ “Бvтэн” гэж баядууд нэрлэнэ. Овлийн улиралд айлууд бэлчээрийн “хил”-ээ тогтоож элсэн овоо босгоно. Хvйтний хэдэн сард айл болгон “хил” дотроо малаа бэлчээнэ. Оглоо аав нь хонио бэлчээрт цуг явж хvргээд, тэр одрийн хонио идээшлvвлэх газрыг мориор давхин зам гаргаж зааж огно. Томчуудын зааж огсон тэрхvv “хил”-ийн дотор л сvргээ онжоох ёстой. Элбэг овстэй газарт бол зааж огсон газрыг бас дахин хувааж, vдээс омо, vдээс хойш гэх маягаар бэлчээрлvвлнэ.

Нэгэнт мал бэлчсэн газрыг “цараа”, малын хол хvрээгvй хэсгийг дээр огvвлсэнчлэн “Бvтэн” гэх аж. Айлууд бие биеийн тэрхvv “Дархан хилийг” хэзээ ч зорчихгvйг хичээнэ. Зорчиж гэмээнэ даруй уулзаж, vг хэлээ ололцоно. Удаа дараа зорчвол малаар торгох, торгуулахдаа хvрнэ. Бэлчээрийн хуваарь зорчих нь тун их ичгvвртэй хэрэгт тооцогддог байлаа. Нэг газрын “цараа” нvнжгээ барахаас нааш солих ёсгvй. Тvвнийг зовхон хотны ахлагч, ганц гэр айлын хувьд орхийн тэргvн л мэднэ. Тийнхvv хил дотор нь хонио ээрэн хариулахад олон сайн тал бий. Хонь боон, бие биенийхээ илчинд даарахгvй, дэмий гvйж хvчээ барахгvй, бэлчээрийн овс сэглэж хаяхгvй.

Бэлчээрээс хонио тууж ирээд хашаанд заавал оруулна. Энэ нь ногоо л бэлчээрээ гамнахтай холбоотой. Бэлчээр холын, ойрын гэсэн ялгаатай. Гэрийн гадуурхи бэлчээр ойрын бэлчээрт орно. Одрийн бэлчээр холынход багтана. Ойр хаяаныхаа бэлчээрийг барчихвал хавар толлосон хонь, эцэж турсан толог, борлон юу идэх билээ? Нялх хурга, ишиг юу идэж, овсонд орох вэ? Хавар олон хоногоор тэнгэр муухайрч, цас шуурвал хэрхэх вэ? Ийм вед ойрхи бэлчээрээ барчихсан айл яах ч аргагvй. “Бvтэн” гэдэг бол тухайн айлын гол нооц, хамгийн vнэт хоронго байжээ. Хот айлын хvмvвсээс нэг нь заавал морио аргамжиж хононо. Оглоо болгон “Бvтэн”-гээ эргэнэ. Айлын мал орж уу, “хил зорчин” ирж хонож уу, зээр гороос ирээд овсийг нь идчихээгvй биз гэж оглоо эрт шалгана. “Бvтэн”-гээ эргэсэн хvн ирэхэд айлын эзэгтэй нар донгож цайгаа чанаж байдаг байжээ. Малын холоор тахчиж гvйцсэн царигийн цас хамгийн тvрvвнд хайлж, дороос нь овс гарч ирнэ. Тэр овсийг бас vхэр, хониндоо хэд хоног идvвлнэ. Баяд тvмний малдаа оны тарга хvч авахуулах арга ийнхvv овормогц байж.

“Таван янзын нутгаас

Тариа аваад жаргаарай” гэж энэ нутгийнхан ероодог байсан нь учиртай ажээ. Таван янзын нутаг гэж юуг хэлдэг вэ гэвэл:

Нэгд, бооргийн (толгод, ухаа) оволжооний дэргэдвэр гарсан ногоо, тал, говийн овс ногоог бууцнаасаа идвүлэх,

Хоёрт, оволжооноосоо гарсны дараа голын хондий дагуу ургасан ширэг овсоор малаа цатгах,

Гуравт, хангай руугаа гарч, шилийн цоо шинэ ногоо идвүлэх. Гэхдээ хангайд хужиргвй тул хэд хэдэн тэмээ хужир аваачиж, бэлчээрт асгаж огно.

Доровт, хангайд хоёр сар орчим болсны дараа говь руугаа эргэж ирнэ. Хоёр сарын дотор говийн овс сайхан сэргэчихсэн, шим швс бүрдчихсэн байна. Тавд, “таар” идвүлэх гэдэг сүүлчийн шат бий. Таар идсэн мал овол турдаггвй, овчин хууч тусдаггвй, ядрахыг мэдэхгвй болдог. Энэ нь зовхон манай нутагт ургадаг олон наст бутлаг ургамал. Зүүнговийн баядууд цасаар битүү хашаа барьдаг, жигтэйхэн дулаахан тул мал зутрах гэж үгвй, мод, чулуу олох гэж зардал тввэг болохгвй. Хавар хайлаад, хойтон нь нэг л одор бариад оволжчих таатай эд байлаа. Манай аав хуц, ухна тавих одроо хэнээс ч бус, аргаль, янгирын ороо орох вейг ажиглаж байгаад товлодог байлаа. Уулын онгон сүргийн эзэд ирэх хаврынхаа цаг агаарыг хүнээс илүү мэддэг байсан учраас тэр. Ийнхүү малын захад онгороосон бага нас, аав, ээжийн минь амьдралын дуурайл надад байгалийн тухай олон ухаарал огсон юм даа.